



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 392

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 05/9012 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Гүнболдыг 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001301



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн
даргыг түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Стратеги төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Батчулууны Мөнхцэцэгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн албан бичгийн хариуг ирэх хүртэл хугацаанд 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс түр томилсугай.

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргын цалинг албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Гүйцэтгэх захирал /Л.Батжаргал/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ